



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ГАЗРЫГ
ТАТАН БУУЛГАХ КОМИССЫН
ДАРГА Н.БАТБААТАР ТАНАА

2015.04.14 № 3/96

Асуудлуудыг хууль эрх зүйн хүрээнд
шийдвэрлэх тухай

Цөмийн энергийн газрын 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дор дурдсан зөрчилтэй асуудлыг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэхийг ТӨХ-ны даргын 2014 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн А/271 дугаар тушаалаар байгуулагдсан Татан буулгах комисст шаардаж байна. Үүнд:

1. Татан буулгах тухай дээр дурдсан шийдвэрийн хүрээнд Цөмийн энергийн газрын дарга байсан Н.Тэгшбаяр 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Б/253 дугаар тушаал гаргаж, орон тооны цомхотголд орсон нэр бүхий 26 хүнд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний /цалингийн нэмэгдэлийг оруулж тооцсон/ тэтгэмжид 100, 6 сая, ТӨХ-ны даргын 2014 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/278 дугаар тушаалыг үндэслэн Татан буулгах комиссын дарга Н.Батбаатар 2015 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Б/01 дугаар тушаал гаргаж, ЦЭК-ын ажлын албанд үлдээнэ гэж тооцсон, орон тооны цомхотголд орсон нэр бүхий 25 хүнд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний /цалингийн нэмэгдлийг оруулаагүй/ тэтгэмжид 100, 3 сая төгрөгийг тус тус олгосон боловч өнөөдөр тэдгээр хүмүүсийн ажилгүйдлийн тэтгэмж авах, нийгмийн даатгалын шимтгэл төлөх асуудал шийдвэрлэгдээгүй, хаана, хэнд, ямар байгууллагад хандахаа мэдэхгүй, тулгамдсан асуудал болж, урьд нь ЦЭГ-т ажиллаж байсан хүмүүсийн эрх ашиг ноцтой зөрчигдөж байна.
2. ЦЭГ татан буугдаж, зарим чиг үүрэг өөр байгууллага, агентлагт шилжсэнтэй холбогдон УУЯ-нд 2, АМГ-т 6, УМХЕГ-т 35 албан хаагч шилжин ажиллаж байгаа бөгөөд тэдгээр хүмүүсээс өнөөдрийн байдлаар эрх ашиг нь хөндөгдсөн тухай асуудал гараагүй байна. Харин тус газарт ажиллаж байгаад жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа, гэрээгээр суралцаж байгаа хүмүүсийн асуудал одоогоор шийдвэрлэгдээгүй, энэ талаар ЦЭК-т ирсэн өргөдөл, гомдлыг ТБК, ЗГХЭГ-т шийдвэрлүүлэхээр уламжилсан байна.
3. Аудит хийх явцад тус газарт 2014 онд хэрэгжсэн Хүн ам, байгаль орчны цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, цөмийн технологи нэвтрүүлэх, олон нийтийн санаа бодлыг судлах дэд төслүүдийн санхүүжилт, гүйцэтгэлийг шалгаж үзэхэд зарим төслүүдийн ажил нь хийгдсэн боловч санхүүжилт нь дутуу байгаа төслүүд байна. Энэ талаар төсөл хэрэгжүүлсэн төслийн удирдагч нартай утсаар холбогдоход төслийг үргэлжлүүлэх, дутуу санхүүжилтээ ЦЭК-оос авах хүсэлээ илэрхийлсэн болно. Тухайлбал: Нэр бүхий 4 төсөлд нийт 29,0 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.


Akt, alban shaardlaga-A4 бланк

Энэ нь Төрийн өмчийн хорооны даргын 2014 оны 12 дугаар сарын А/271 дугаар тушаалын 2-т “Цөмийн энергийн газрыг татан буулгах ажлыг Монгол Улсын Ерөнхий сайдын 2014 оны 136 дугаар захирамж, Төрийн өмчийн хорооны даргын 2014 оны А/220 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс чиглэл авч, хуулийн хүрээнд хийж гүйцэтгэн Төрийн өмчийн хорооны хуралдаанд тайлагнахыг Комиссын даргад үүрэг болгосугай” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн дээр дурдсан асуудлуудыг хууль, эрх зүйн хүрээнд, ажиллагсдын эрх ашгийг хохироохгүйгээр шийдвэрлэх шаардлагатай байна.

5. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2015 оны 4 дүгээр сарын 30 - ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн өмчийн хорооны татан буулгах комиссын дарга Н.Батбаатарт хариуцуулав.

АХЛАХ АУДИТОР



Ц.ЦЭРЭНХҮҮ